

130 ХЭРХЭН СУРАЛЦАХЫГ СУРАХУЙ

130.1 СУРАЛЦАХЫН ТУЛД ХУУЧНЫГ ОРХИЖ СУРАХ

Даруу, гэмшсэн сүнсээр л "ИТГЭЛ"-ийн үүдийг нээж "ИТГЭЛ"-ийн гүүрийг давж " АГУУ НЭГЭН" – ийг олох болно.

- **Итгэлээр алхах үед**

⁶Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурхан уруу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой. (Еврей 11:6 АБ 2004)

Шинэ зүйл сурахын тулд та хуучнаа орхих ёстой. Үгэнд бодол санаагаа биш, бодол санаагаа Үгэнд хэрхэн нийцүүлэхийг суралцаарай. Зохисгүй бодол нь буруу зам руу хөтөлдөг. Бодол дотроо дайснууд үүрлэхийг бүү зөвшөөр. Сүнсээрээ даруусаж, гэмшиж чадвал Түүний Үгсийн оршихуйг мэдэрч улмаар хэрэггүй угшмал бодлоо хаяж сурах болно.

Мэтгэлцээн нь хариулт өгөх бус мэтгэлцээнд хүргэдэг бөгөөд маргалдаан нь "тайлбарлагдашгүйг" тайлбарлаж чадахгүй.

- **Нүглийн улмаас хаагдсан ивээлийн хаалгыг нээ**

¹¹Тахилч болгон өдөр бүр үйлчлэн, нүглийг хэзээ ч зайлуулж үл чадах өнөөх л тахилуудаа дахин дахин өргөсөөр зогсдог. ¹²Харин Тэр үүрд нүглийн төлөө нэг тахилыг өргөөд, Бурханы баруун гарт заларсан бөгөөд ¹³Өөрийнх нь дайснуудыг хөлийнх нь гишгүүр болгох хүртэл тэр үеэс хойш хүлээж байна. ¹⁴Учир нь Христ ариун болгогдогсдыг ганц тахилаар үүрд төгс болгожээ. ¹⁵Ариун Сүнс бидэнд мөн гэрчилдэг. Учир нь Тэр¹⁶“Эзэн айлдаж байна.“Тэр өдрүүдийн дараа тэдэнтэй байгуулах Миний гэрээ энэ юм.Би Өөрийн хуулиудыг тэдний зүрхэнд тавина.Би тэдгээрийг тэдний ухаан санаанд бичнэ” ¹⁷цааш нь “Би цаашид тэдний нүглүүд,Тэдний хууль бус явдлыг санахгүй”” ¹⁸Эдгээр зүйлсийн уучлал байгаа газар нүглийн төлөөх тахил цаашид байхгүй болдог. (Еврей 10:11-18 АБ 2004)

⁷Би гэрлийг буй болгон, харанхуйг бүтээж, энх амгаланг тогтоон, гай гамшгийг ч бүтээж байна. Би бол энэ бүгдийг хийдэг ЭЗЭН мөн. (Исаиа 45:7 АБ 2004)

- **Сонсох сонорыг нээх**

¹⁰Шавь нар нь Түүн уруу ирж, -Та яагаад тэдэнд сургаалт зүйрлэлээр ярьдаг юм бэ? гэхэд ¹¹Тэр-Тэнгэрийн хаанчлалын нууцуудыг мэдэх нь та нарт өгөгдсөн юм. Харин тэдэнд өгөгдөөгүй. ¹²Учир нь хэнд байна, түүнд ихээр өгөгдөж, элбэг дэлбэг байх болно. Харин хэнд байхгүй байна, түүнд байгаа нь хүртэл түүнээс авагдана. ¹³Тэд харавч хардаггүй, сонсовч сонсдоггүй бөгөөд ойлгодог ч үгүй учир Би тэдэнд сургаалт зүйрлэлээр ярьдаг. (Матай 13:10-13 АБ 2004)

²³Миний зэмлэлд эргэн ханд. Харагтун, би та нарын дээр сүнсээ бялхуулна, та нарт үгээ мэдүүлнэ. (Сургаалт үгс 1:23 АБ 2004)

- **Ерөөлийн замыг олох**

¹⁷Намайг хайрлагсдыг би хайрлана. Намайг хичээнгүйлэн хайдаг нь намайг олно. ¹⁸Баялаг, алдар суу, үргэлжид байх хөрөнгө болон шударга зөв нь надад байгаа. ¹⁹Миний үр жимс алтнаас ч, Тэр ч байтугай шижир алтнаас ч илүү дээр. Миний үр ашиг нь цалин цагаан мөнгөнөөс ч илүү дээр. ²⁰Би шударга зөвийн замаар, шударга байдлын жимээр явдаг ²¹Энэ нь намайг хөрөнгөөрөө хайрлагсдад ивээлийг хүртээх бөгөөд Тэдний эрдэнэсийн санг дүүргэхийн тулд юм. (Сургаалт үгс 8:17-21 АБ 2004)

130.2 ИТГЭЛИЙН НУУЦ

Дээрээс ирэх ерөөлүүд зөвхөн ИТГЭЛИЙН замаар дамжин ирдэг бөгөөд ИТГЭЛ нь зөвхөн ИТГЭЛээр л ирдэг. Энэ бол ИТГЭЛИЙН тэрхүү нууц юм.

- **Дуулгавартай байх нь итгэлийг баталдаг**

¹Ах дүү нар аа, миний зүрх сэтгэлийн хүсэл болон тэдний төлөө Бурханд хандах миний залбирал нь тэдний аврал билээ. (Ром 10:1 АБ 2004)

⁴Харагтун, бардам нэгний хувьд, доторх сэтгэл нь зөв бус байдаг юм. Харин зөвт хүн итгэлээрээ амьдарна. (Хабаккук 2:4 АБ 2004)

⁶Тэгээд тэр надад -Энэ бол Зеруббабелд хандсан ЭЗЭНий үг юм. “Хүч чадлаар ч бус, эрх мэдлээр ч бус, харин Миний Сүнсээр” гэж түмэн цэргийн ЭЗЭН айлдаж байна. (Зехариа 4:6 АБ 2004)

¹³Харин Есүс хариуд нь -Тэнгэрлэг Эцэгийн минь тариагүй алив ургамал үндсээрээ сугалагдана. (Матай 15:13 АБ 2004)

⁴Даруу зан хийгээд ЭЗЭНээс эмээхүйн шагнал болбоос Амь, алдар хүнд, эд баялаг юм. (Сургаалт үгс 22:4 АБ 2004)

- **Итгэлээрээ алхах**

⁹Би чамд тушаагаагүй гэж үү? Тууштай бөгөөд зоригтой бай! Хаана явсан газарт чинь чиний Бурхан ЭЗЭН чамтай хамт байх учраас бүү чичирч айгтун гэв. (Иошуа 1:9 АБ 2004)

³³Харин эхлээд Түүний хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно. (Матай 6:33 АБ 2004)

²⁴Дэлхий дээр өчүүхэн атлаа үнэнхүү мэргэн дөрвөн зүйл бий.

²⁵Шоргоолж бол том амьтан биш ч гэсэн зуны турш хоол хүнсээ базаана. ²⁶Дорго бол хүчтэй амьтан биш ч гэсэн хад чулуун дотор үүрээ засна. ²⁷Царцаанд хаан байхгүй ч тэд бүгд дэг журамтай. ²⁸Гүрвэлийг гараараа барьж чадах ч тэр нь хааны ордонд байх ажээ. ²⁹Алхах гишгэхдээ сүрлэг гурав буюу бүр дөрөв бий. ³⁰Хэний ч өмнөөс ухардаггүй араатны дунд хүчирхэг арслан, ³¹Азарган тахиа, ухна ба дайчин баатруудтайгаа хамт буй хаан болой. (Сургаалт үгс 30:24-31 АБ 2004)

⁵Бурханы үг бүр соригдсон. Тэрээр Өөрийнх нь дотор хоргодогсод бамбай юм. ⁶Түүний үгэн дээр бүү нэм. Тэгвээс Тэр чамайг буруутгаж, чи худалч болох вий. (Сургаалт үгс 30:5-6 АБ 2004)